



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 1/70

Биндэр сум

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний
ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.5, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/212 дугаар захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: - Х.Гэлэгжамц (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүд:

- Н.Болормаа (Баян-Өндөр багийн Засаг дарга)

- Э.Мөнгөншагай (Мандалхаан багийн Засаг дарга)

- Ж.Ганзоригт (Баянгол багийн Засаг дарга)

- Х.Амарзаяа (Дэлгэрхаан багийн Засаг дарга)

- Б.Тунгалаг (Онон багийн Засаг дарга)

2.Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалт, лабораторийн шинжилгээний төлөвлөгөөт арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасагт даалгасугай.

3.Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг орон нутагт графикт хугацаанд нь шуурхай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт,

Урьдчилан сэргийлэх, дархлаажуулалт, лабораторийн шинжилгээ, халдваргүйтгэлийн ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Х.Гэлэгжамц)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

